

Санхүүгийн салбарын хямралыг зохицуулах нь: Монгол улсад хэрэг болохуйц олон улсын туршлагаас

Илтгэгч: Дэлхийн банкний Зүүн ази, номхон далайн бүсийн тэргүүлэх эдийн засагч Викрам Нерү
(Улаанбаатар хот, 2009 оны 10-р сарын 29)

Энэхүү бодлогын чуулга уулзалтанд урьж оролцуулсан явдалд {зохион байгуулагч нарт} талархлаа илэрхийлье. Монгол Улсын бодлого боловсруулагчид, өр засаг, нийгмийн төлөөллийн өмнө энэ чухал сэдвээр илтгэл тавих боломж олдсонд гүн талархаж байна. Монгол Улс өөрийн санхүүгийн салбар дахь гадаад хүчин зүйлсийн нөлөөллийг системийг хамарсан хямрал болж даамжирхаас сэргийлэх арга хэмжээ авч байгааг үгтэй давхцан болж байгаагаараа энэхүү чуулга уулзалт онцлог юм. Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ эрх баригчид өмнөх түүхэн сургамжуудаас санаа авч бодлоготой хандах хэрэгтэй.

Испани, Америкийн 19-р зууны философич Жорж Сантаяна "Өнгөрсөн түүхээс сургамж авч чаддаг хүмүүс алдааг заавал давтдаг" гэж хэлсэн байдаг. Санхүүгийн хямралын чиглэлээр олон судалгаа шинжилгээ хийгдсэн байдгийг үндэслэн энэ талаар бидэнд түүхэн сургамж юу байна, улс орнууд санхүүгийн хямрал үүсэх эрсдэлийг хэрхэн бууруулах талаар энэхүү илтгэлээ бэлтгэлээ. Хөгжингүй улс орнуудад бий болсон саяхны санхүүгийн хямрал барууны онолоор хүмүүжсэн эдийн засагч, санхүүгийн шинжээчдийн аль алиных нь нэр хүндийг унагаасныг би ойлгож байгаа ч энэ бүхнийг өөр өнцгөөс харж байна. Өөрөөр хэлбэл, энэ хямрал бол эдийн засаг, санхүүгийн онолын суурь зүй тогтол, хуулиудын ялалт байлаа. Дэлхийн хамгийн хүчирхэг улс гүрнүүдэд ч гэсэн эдгээр хуулиуд адил тэгш үйлчилж, хуулиудыг үл тоосон нь өөрсдийгөө аюулд оруулж байдаг байна.

Нэг сарын өмнө дэлхий дахин Lehman Brothers компани 2008 оны 9-р сарын 15-нд мөхсөний нэг жилийн ойг дурсан саналаа. 1800 он, Наполеоны зарласан дайны үеэр Данид үүссэн санхүүгийн үймээнээс хойшхи 210 жилийн түүхэнд дэлхийн хэмжээнд банкны 258 хямрал болж байжээ.¹ Өөрөөр хэлбэл, нэг жилд нэгээс олон оронд хямрал болж байжээ. Хөгжиж байгаа улсуудын хувьд нэг таатай мэдээ гэвэл өндөр орлоготой улсууд хөгжиж байгаа улсуудтай ижил давтамжтайгаар хямралд өртөж байна. Саяхан хэвлэгдсэн нэг материалын үндрийг маш товчхон илэрхийлсэн байсан: "Банкны хямрал: Ижил магадлалтай аюул". АНУ-ын эдийн засгийн Их хямралын үеэр банкны хямрал хамгийн олон удаа болж, 21-р зууны анхны санхүүгийн их хямрал илүү их аюул заналхийлж байна. Өнгөрсөн хугацаанд болж байсан хямралууд ихэнхдээ бүтцийг хамарсан (1930-аад оны эхэн үеийнхээс бусад) байсан бол нөөгийн хямрал үнэхээр дэлхий дахиныг хамарч, хөгжингүй улсуудыг хөлдөө сөхрүүлэн тив дэлхийн хөгжиж буй улсуудад үймээн сандрааныг бий болголоо. Банкны систем үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудаас ялгаатай нь нэг төрлийн бүтээгдэхүүн буюу мөнгөөр бизнес хийдэг, мөн системийн нэг хэсэг бий болсон цочролыг эв зохицуулж чадахгүй бол буудал хэсгүүд рүүгээ түргэн халддаг энгийн учир шалтгааны улмаас аль ч улс банкны хямралд өртөхгүй

¹ Банкны хямрал: Ижил магадлалтай аюул

байж чадахгүй. Үнэндээ яг одоо олон улс орон банкны хямралын давалгаанд байгаа. Тэгэхлээр Монгол Улс онцгойлон санаа зовних хэрэггүй. Дэлхийн 2-р дайнаас хойш 2007 оныг хүртэл дэлхий дээр дөрвөн улсад банкны хямрал болоогүй: Австри, Бельги, Голланд, Португал. Гэхдээ эдгээр улсууд одоо хямралын золиос болчоод байгаа. *{Слайдууд дээр түүхэн тоо мэдээг агуулсан хүснэгтийг оруулж болох юм}*

Банкны хямралын давтамж, үргэлжлэх хугацаа хөгжингүй болоод хөгжиж байгаа улсуудад ижил байгаагийн зэрэгцээ хямралд хүргэсэн нөхцөл байдал, хямралын үр дагаврууд нь мөн ижилхэн байгаа нь сонирхолтой юм. Хямралд хүргэсэн нөхцөл байдлын хувьд хөрөнгийн урсгал олон улсын түвшинд чөлөөтэй байх нь банкны хямралд олон удаа үргэж байжээ. Өөрөөр хэлбэл 1990 -ээд оноос өмнө ч ийм байдал үүсдэг байсан байна. Тухайн улсад гадаадаас их өрөнгө орж ирэх, эсвэл бараа түүхий эдийн экспортоос их хэмжээний орлого олох замаар хөрөнгийн орох урсгал асар их болсноор банкны хямраа үүсэх магадлал нэмэгддэг байна. Ер нь хөрөнгийн асар их хэмжээний орох урсгал нь зээлийн өндөр өсөлтийг дагуулж, биет өрөнгийн үнийг өсгөн (биет хөрөнгийн үнийн хөөсийг бий болгож) амжилтанд үрэх магадлал багатай, эрсдэл ихтэй хөрөнгө оруулалтуудын санхүүжилтэнд явдаг. Зориг дүрэн, уужуу тайван Сангийн сайд, Төв банкны ерөнхийлөгч хоёр хоёулаа найр эхлэхэд идээтэй тавгыг авч тавих эр зориг, шийдэмгий зантай байх ёстой. Хямрал мөн өөрийн гэсэн дотоод учир шалтгаантай байдаг. Тухайлбал, эрсдэлийг хэт доогуур нэлэх, хэт их өлөөт эх үүсвэр бий болгох, хэт их зээлээр сэржүүлэх, хувьцаа эзэмшигчид, удирдлага өнм түүнчлэн түншүүдтэйгээ үг хэлээ олохгүй байх, муу засаглал, банкны хяналт зохицуулалт, шалгалт хангалтгүй байх, хэний ч ойлгодоггүй нарийн төвөгтэй бүтэцтэй үнэт цаас. *{Слайдууд дээр өрөнгийн гадаад урсгал болон хямрал, мөн хямрал, эрсдэлийн нэмэгдэл үү доогуур байхын харилцан хамаарлыг харуулсан хүснэгт, зураг оруулж болох юм.}*

Хямрал хэр өртөгтэй тусч байна вэ? Нилээд их хэмжээний алдагдал авчирдаг. Саяхны банкны хямралын улмаас Индонези Улс гэхэд ДНБ-ийхээ 50 гаруй хувь, Турк Улс 30 хувьтай тэнцэх хэмжээний өрөнгийг төсвөөсөө гаргажээ. Үүнд муу активын өр барагдуулалтыг тооцсон болно. Харин Малайз Улс 4 хувьтай тэнцэх хэмжээний өрөнгө гаргасан нь бага үзүүлэлт болж байна *{Швед Улс х хувь}*. Өнгөрсөн 30-аад жилд хөгжиж буй улсуудад болсон банкны хямралуудын улмаас эдгээр улсуудын өсвөөс гарсан нийт өрөнгө олон улсын хамтын нийгэмлэгээс үзүүлсэн тусламжийн өссөн дүнгээс давсан байна. Хамгийн гол нь эдийн засгийн бодит өсөлт банкны хямралаас хойш нилээд удаан хугацаанд уналтын байдалд байж, дунд хугацаанд үрхэл хямралаас өмнөх төлөв байдалдаа эргэж орж чаддаггүй байна. Хямралын дараагийн гурван жилд засгийн газрын өрийн үлдэгдэл дунджаар хоёр дахин нэмэгддэг нь хамгийн санаа зовоосон асуудал юм. Мэдээж хэрэг, өрийн өсөлт хямралын дараах гурван жилээс хэтрэх нь олонтаа тохиолддог. Тухайлбал, Япон Улсын өр арваад жил нэмэгдэж ирсэн. *{Слайдууд дээр хямралыг гэтлэн давах зорилгоор өсвөөс гаргасан өрөнгө, засгийн газрын өрийн өсөлт, өнөөгийн хямралын үед засгийн газруудын авч хэрэгжүүлсэн бодлого, гаргасан өрөнгө зэргийг харуулсан хүснэгт, график оруулж болох юм.}*

Тэгэхлээр хямралаас зайлсхийж чадвал эдийн засгийн өсөлтийг урт хугацаанд тогтвортой хангаж чадна. Гэхдээ яг одоо энэ шатанд Монгол Улсын хувьд банкны хямрал үүсэхээс сэргийлж, үүссэн нөхцөлд шуурхай арга хэмжээ авахад анхаарах

нь чухал байна. Өнгөрсөн хугацаанд банкны олон тооны хямралууд болж байсан учраас тэдгээрийн туршлага, сургамжийг дотор өнөөгийн хямралыг зохицуулах туршлага, сургамжүлэмж их байна . 1997 онд Индонези Улсад асар их хэмжээний алдагдал учруулсан банкны хямралыг би өөрийн бие эр үзэж, хямралын нөлөөллийг хумих, шийдвэрлэхэд зөвлөлгөө өгч байсан билээ. Мөн түүнчлэн, өнгөрсөн нэг жилийн хугацаанд Вашингтон хотод ажиллаж байхдаа өнөөгийн санхүү эдийн засгийн хямралын өрнөл, аюул занал, АНУ-ын төв банк, Сангийн яамнаас авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээнүүдийг ажиглаж суулаа.

Банкны хямралын талаар хуримтлуулсан хувийн туршлага, судалгаа шинжилгээний бүтээлүүдийг уншиж танилцсаны үндсэн дээр дараах гурван сургамжийг олж харсан бөгөөд бодит байдал дээр нүүр тулан ажилладаг хүний хувьд хэзээд санаж явах болно. Нэгдүгээрт, түргэн шуурхай арга хэмжээ авах. Хоёрдугаарт, сайн бэлтгэлтэй байх. Гуравдугаарт, ил тод байх. Эдгээрийг дэлгэрүүлж ярихыг минь зөвшөөрнө үү.

Түргэн шуурхай арга хэмжээ авах

Нэгдүгээрт: түргэн шуурхай арга хэмжээ авах. Хямрал болох нь гарцаагүй эсвэл эхэлж байгаа, мөн төр засгаас олон нийтийн итгэлийг авч үлдэж, түргэн сэргээх бодлого баримталж байгаа бол хурдтай байх нь шийдвэрлэх ач холбогдолтой. Банкны хямралын хамгийн үнд хэлбэр болох банк дампуурсан тохиолдолд төр засаг шуурхай хариу үйлдэл хийж, нэмэгдэл эх үүсвэр гарган өгч, хадгаламж, бусад өр төлбөрт баталгаа гаргаж, цаашилбал зээлдүүлэгчийн эрхийг түр түдгэлзүүлэх хүртэл арга хэмжээ авч болно. Чухам ямар хариу арга хэмжээ авахыг тухай улсын нөхцөл байдал, баталгаа гаргахгүй байснаар асуудлыг шийдвэрлэж болох зэргээс хамааран цаг хожихүүднээс авч тэдгээрийг эвхэн нэг л удаа хэрэглэж болно . Хамгийн гол нь тухайнхөл байдалд арга хэмжээ авахгүй хүлээлгэснээр алдагдал үүсэхийг ухамсарлах ёстой. Банкны өөрийнх нь ажиллагсад банкны хөрөнгийг зувчуулах, банкаа дампуурлаас аврахын тулд активаа хуваажүүл эрсдэлтэй төслийг санхүүжүүлэх зэргээр тэрхүү алдагдлыг улам бүр нэмэгдүүлдэг. Зарим хүмүүс энэ үйлдлийг “сэргэлтийн төлөөх болчимгүй бооцоо” гэж нэрлэдэг. Шаардлагатай арга хэмжээг эртхэн аргаар сүүлд үүрэх төсвийн зардал нэмэгддэг. Банкийг хааж татан буулгах нь туйлын өрөг арга хэмжээ гэж үздэг учраас ихэнх бодлого боловсруулагчид энэ шийдвэрийг хойш тавьдаг. Харин ч шаналалт өвчинг таслан зогсоож, дампуурсан банкны (банкны тодорхой үнэ цэнэ үлдсэн бол) үйл ажиллагааг шинээмчлөгчийн нэр дор зах зээл үрүү эргүүлж оруулах учирүүнийг эерэг зүйлээр харах ёстой юм. Зарим банкуудыг хүчин төгөлдөр хууль тогтоомж, журмын дагуу шууд дампууруулахад дээрх том байж болох нь үнэн. Гэхдээ АНУ, Европын томоохон улсуудын туршлага аль ч банк шуурхай арга хэмжээ авахад томдүйх болохыг харууллаа . {Слайдууд дээр өнөөгийн санхүү эдийн засгийн хямралын үед улс орнуудын төр засгаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний цаг хугацааны дарааллыг харуулсан хүснэгт оруулж болох юм.}

Эцэст нь, санхүүгийн болоод макро эдийн засагт гарсан бужигнаан банкны хямралд хүргэж, банкны ажилтнууд тэдгээрийн хяналтаас гадуурхүчин зүйлийн золиос болдог байж болох талтай. Ийм нөхцөл байдалд журам зааврыг асуудлыг дэвэргээх хүчин зүйл болгохгүйн үүднээс төр засгаас өөрийн хөрөнгийн зохистой харьцаа, зайлшгүй байх нөөцийн үзүүлэлтүүдийг зөөлрүүлж өгдөг.

Дүгнэж хэлэхэд, хямралын хүрээг тархаахгүй байж, итгэлийг сэргэхийн тулд бодлогын хариу арга хэмжээг аль болохүргэн шуурхай авч хэрэгжүүлэхэд тухайн хямралын учир шалтгааныгүнэн зөв тогтоосон байх ёстой. Энэ үе шатанд буруу шийдвэр гаргаснаар эргэж буцаашгүй үр дагаварт хүргэж, үүссэн алдагдлын зардлыг хуваарилах асуудлыг хүндрүүлж болзошгүй байдаг.

Эндээс хоёр дахь чухал сургамж маань урган гарч байгаа юм.

Бэлтгэлтэй байх шаардлага

Тухайн улс орон банкны салбарын хямралыг хяналтандаа авч чадсан эсхүл шийдлийг олж чадсан эсэхээс үл шалтгаалан, үйл ажиллагаа нь суларчихаагүй, ашигт ажиллагаатай хэвээр байгаа аж ахуйн нэгжүүдийн гарт үр өгөөжтэй нөөцүүдээ болон банкны франчайзыг төвлөрүүлэх чухал зорилт тавигдсан тийм цаг мөчид юу хийх, хэн хийх, хэрхэн хийх нь тодорхой бус байх нь буруу шийдвэрүүд гаргах, үнэт цагийг алдах, эцэст нь санхүүгийн ачаалал хэт ихэсч бүтээгдэхүүний гаргалт багассанаас үүдэж өртөг өндөрсөх эрсдэлтэй.

Хамгийн түрүүнд, чухам *хэрхэхийг мэдэх нь* чухал. Швед Улсын жишээг харъя. Бүр анхнаасаа, Шведийн Банкуудыг дэмжих байгууллага нь (1992 оны сүүлээр байгуулагдсан) due diligence буюу дүн шинжилгээний аргаар нөхцөл байдал хэр муудсаныг тодорхойлсон байна. Туслалцаа хүссэн банкууд тухайн байгууллагын ажилтнуудад баримтаа бүрэн дэлгэх шаардлагатай болсон. Хийсэн дүн шинжилгээн дээрээ тулгуурлаад туслалцааг адил бус хэлбэрээр олгосон байна. Хувийн эздүүд банкныг татан буулгахтай болон үндсэн хөрөнгийг балансаас хасахтай холбогдсон зардлаас хуваалцах үүрэгтэй байв. Азийн хямралын үеэр хямралд хамгийн ихээр нирвэгдсэн улсууд үүнтэй ижил төстэй байдлаар асуудалд хандсан байна. Батлан даалт олгож бизнесүүдийг аврах үйл ажиллагааны эхний үе амжилтгүй болж өнгөрсний дараа Өмнөд Солонгосын Засгийн газар бизнесийн салбарын үйл ажиллагааг хянан шалгах Ерөнхийлөгчийн хороог байгуулж, дүнд нь 55 компанийг дампуурсан гэж тодорхойлсон. Индонез Улсад эдийн засаг нийгмийн хямралын оргил үе болох 1998 оны эхээр эрх бүхий байгуулагууд долоон банкныг мэдэлдээ авсанаар тэдгээрийг дампуурал болон хөрөнгийн үгүйрлээс (хөрөнгийг Здагч этгээдэд зарж борлуулах ажиллагаа) аварч чадсан. Улмаар Индонезийн Засгийн газар бүх 211 банкныг аудитад хамруулж, тэгсэний дараа цааш хэгэжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж улмаар хэрэгжүүлж эхэлсэн байна. Аливаа улс хямралын симуляцийг ашиглаж өөр өөрсдийн бэлэн байдлыг шалгаж байх нь зүйтэй. Тэрхүү “байлдааны бэлэн байдлын тоглолтууд” нь институцийн, эрх зүйн болон харилцаа холбооны чиглэлээр оршиж буй сул талуудыг илрүүлэх ач холбогдолтой хэрэгсэл юм. Ийм төрлийн үйл ажиллагаагаар болон бусад аргаар буй болсон хүндрэлийн цар хүрээг тогтоох дүн шинжилгээ хийж чадвал засгийн газраас авах арга хэмжээний үр дүнг дээшлүүлж татвар төлөгчдөд учрах зардлыг хэмнэнэ.

Хоёрдугаарт, *хэрхэн хийхийг* заасан хөтөлбөр боловсруулах шаардлагатай. Ихэнх тохиолдолд хямралын эхэн үед хэрэгжүүлэх бүх нийтийн сандралыг дарах үүрэгтэй арга хэмжээнүүд нь “муу” хөрөнгийг хасах болон салбар хамарсан бүтцийн өөрчлөлт хийхийн наагуур арга хэмжээ болж хувирдаг байна. *Хэрхэн хийхийг* заасан хөтөлбөр нь бүтцийн хамааралтай асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн стратеги болон хэрэгжүүлэх төлөвлөгөөг агуулах

бөгөөд тэдгээр нь маш найдвартай мэдээлэл дээр суурилах, эрх зүйн болон зохицуулалтын тодорхой орчинд хэрэгжих, эдийн засаг санхүүгийн суурь хуулиудыг харгалзсан байх учиртай. Хурдацтай өрнөж буй хямралыг тогтворжуулахад чиглэсэн арга хэмжээ нь бодит байдлаас гажсан, үр ашиггүй байх хандлагатай байдаг. Огт нөхцөлгүйгээр батлан даалт гаргах нь шударга өрсөлдөөнийг зөрчилдүүлж санхүүгийн том хариуцлагад хүргэж болзошгүй. Тогтолцооны хүрээнд өндөр ач холбогдол бүхий банкуудад хийх улсын том хэмжээний хөрөнгө оруулалтууд нь хэт удаан үргэлжилвээс засанглалын хэвийн хэм хэмжээг тогтворгүй болгох аюултай. *Хэрхэн* хөтөлбөр нь нэгэнт үүссэн гаж байдлаас хэрхэн гарах зохистой замыг мөн заасан байх учиртай. Эцэст нь, олон улсын туршлагаас харахад бүтцийн өөрчлөлт хэрэгжүүлэх хөтөлбөр харьцангуй хөгжсөн эрх зүйн болон зохицуулалтын орчинд хэрэгжсэн тохиолдолд илүү үр дүнтэй бөгөөд татвар төлөгчид илүү бага зардалтай тусдаг байна. Эдгээр хөтөлбөрүүд нь дампуурал, хөрөнгө хураалт, хасалт, ил тод байх болон нягтлан бодох дүрмүүд, хөрөнгө эзэмшигчид/зээлдүүлэгчдийн эрхийн асуудал зэргийг зохицуулах эрх зүйн орчны дунд хугацааны төлөвлөгөөг зайлшгүй агуулна.

Хэн хариуцлага хүлээх вэ гэдэг асуудал мөн чухал. Хямралыг шийдэх, банкуудад бүтцийн өөрчлөлт хийх үүрэг хүлээсэн байгуулагууд эрх зүйн ил тод эрх мэдэл олгогдсон байх шаардлагатай. Засгийн газрын аль байгуулага, харьяа газар юуг хариуцаж буйг маш ойлгомжтойгоор харуулсан “байлдааны эрэмбэ” боловсруулах шаардлагатай. Украин Улсад төв банк болон сангийн яамны хоорондын уялдаа холбоо асуудалтай байсан тул засгийн газраас банкны салбарын бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх тусгай хороо байгуулсан байна. *{оноосон нэрийг тодруулж тус хорооны үүрэг, үйл ажиллагааны цар хүрээ, хамаарлын схем зэргээр хэдэн өгүүлбэр нэмж оруулах }.*

Ил тод байх шаардлага

Дорвитой бэлтгэл нь засгийн газраас банкны салбарт бүтцийн өөрчлөлт хийж хямралыг гэтлэн давах зорилгоор хийх интервенцийн чанарт шууд төлөөлөх боловч, зөвхөн ил тод байдал эцсийн дүнд бүх зардлыг үүрч гарах татвар төлөгчийн итгэлцлийг төрүүлдэг. Банкны салбарын хямралыг шийднэ гэдэг эцсийн дүнд банкны систем дэх нийт алдагдлыг хадгаламж эзэмшигчид, зээлдүүлэгчид, хувьцаа эзэмшигчид, банкны менежерүүд болон татвар төлөгчийн дунд хэрхэн хуваарилах вэ гэдэг асуудал дээр тулгуурладаг. Энэхүү процессийг зохицуулах эдийн засгийн хууль гэж үгүй, энэ нь эцсийн дүндээ улс төрийн шийдвэр юм. Хадгаламж эзэмшигчид, зээлдүүлэгчид, хувьцаа эзэмшигчид зах зээлийн хуульд захирагдан ачааны ихийг үүрэх боловч банкны тогтолцоод итгэх итгэлцэл буурсанаар нийгэм эдийн засгийн хэт өндөр өртөг дагуулна. Нийгмийн өндөр өртгийг гаргахгүй байх нь татвар төлөгчийн гол ачаалал юм.

Гэхдээ татвар төлөгч ийм өндөр ачааллыг хүлээхийн тулд шударга байдал байгаа эсхэд итгэлтэй байх шаардлага гарна, үүний тулд нотолгоо шаардагдана. Тиймээс, хадгаламж эзэмшигчид хамгаалагдсан хэдий ч, засгийн газар хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчдийн зүгээс хүлээх зардлын талаар ил тод мэдээлэх шаардлагатай. Хэрэв менежмент буруутай гэж тооцогдож байгаа бол хямралыг шийдвэрлэхэд тэдгийг зайлуулах явдал

чухал. Хүний нөөцөөр дутмаг зарим орнуудад сүйрсэн банкны менежментийг хэвээр хадгалж дээр нь хянах үүрэгтэй баг оруулдаг байна. Хэрэв бизнесийн эздүүдэд асуудал оршиж байгаа бол албан журмын балансын хасалтын замаар хөрөнгийн алдагдлаас хуваалцана. Тогтолцооны хувьд өндөр ач холбогдолтой банк хүнд байдалд орсон тохиолдолд нэгтгэх, эзэмших замаар эзэмшлийг өөрчлөх хувилбар бас байж болох юм.

Активын менежментэд ил тод байдал ялгаагүй чухал, энэ нь зээлийн дахин төлөвлөлт, эргэн төлөлт, мөн активын менежментийн компани мэтийн төвийн агентлагаас дампуурсан банкуудын активыг зохицуулах үйл ажиллагаанд чухал байдаг. Ялангуяа төрийн өмчит активын менежментийн компаниуд нь улс төрийн шахалт хавчилтад хамгийн их өртдөг. Дампуурсан банкуудын активын үлдэгдэл үнэ цэнг нөхөн бүрдүүлэх чадавхи нь банкны салбарын хямралын өртгийг бууруулахад тэдгээр компаниуд хичгээн чухал гэдгийг харуулдаг. Тиймээс тэдгээрийн эрх зүйн статус болон бие даасан байдал нь баталгаажсан байх шаардлагатай бөгөөд тудний арга барил, систем, менежментийн томилолтууд, менежментийн шийдвэрүүд, дансууд зэрэг нь нээлтэй, ил тод байснаар итгэл үнэмшилтэй байж чадна. Үүнээс дутуугүй, магад илүү чухал зүйл юу вэ гэвэл, эдгээр агентлагуудад хөрөнгө шилжих явцад байх ёстой ил тод байдал. Шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой заагаагүй, хөрөнгө шилжүүлэх процессийн дүрмийг болон үнийг ил тод болгоогүй нь активын менежментийн олон компанийг амжилтгүй болоход хүргэсэн. Тэдгээр дүрэм болон шалгуур үзүүлэлтүүдийг нийтэд зарлах хэрэгтэй. *{слайдуудад активын менежментийн компаниудын үр ашигтай байдлыг харуулсан зарим хүснэгт, зураг оруулах}*

Эдгээр сургажлийг Монголыг нөхцөлд ашиглах нь

Жижиг бөгөөд маш нээлттэй эдийн засгийн хувьд, Монгол Улс нь гадгы нөлөөнд өртөмтгий байх талтай. 1990-ээд онуудад хойно хойноосоо дагасан санхүүгийн гурван хямрал болсон. Энэ удаад ч мөн адил тус улсын банкны салбар бүс нутагтаа хамгийн хүндээр өртөгдсөн нь билээ. Тогтолцооны шинж чанартай бэрхшээлүүд дэлхийн эдийг засгийн удаашрал болж эхлэхээс өмнө ажиглагдаж байсан. 2008 оны дунд үеэс банкуудын чанаргүй зээлийн эзлэх хэмжээ өсч эхэлсэн бөгөөд хадгаламж банкны салбараас гадагш урсч эхэлсэн. Үндэсний мөнгөний нэгжийн үнэгүйдэл 2008 оны намар болж эхэлсэнээр 2009 оны 3-р сар гэхэд төгрөгийн ханш 38 хувиар буурсан байна. Бэлэн мөнгөний хэмжээ боломжийн хэмжээнд байгаа мэт харагдаж байсан бол гэнэт алга болоход хүрсэн. Активын хэмжээгээрээ хамгийн томоор тооцогддог хөрөнгийг биржид бүртгэлтэй хоёрхон банкны нэг Анод банк нь хаггдахад хүрсэн.

1990-ээд оны хямралуудын үеийн удааширсан хариу арга хэмжээтэй харьцуулахад Засгийн газраас 2009 оны эхээр авсан арга хэмжээ нь үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэлийг буцаан сэргээж нийтийг хамарсан сандрал тархуулаагүй. Гэхдээ хямрал мэт байдалд аваачсан суурь шалтгаанууд байсаар байна. Сүүлийн үеийн байдлыг харахад банкны салбарын сүтцийн өөрчлөлт хийх цогц хөтөлбөрийг дэмжсэн улс төрийн дэмжлэг буй болоод байх шиг байна. Засгийн эрх баригчид тийм төрлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхдээ дээр дурьдсан олон улсын туршлагыг харгалзаж үзнэ гэдэгт найдаж байна. Санхүүгийг салбарыг шинэ шатанд аваачих үндэс суурийг тавьсан, хүмүүсийг санхүүгийн эх үүсвэрт ойртуулж чадсан 2000-аад оны оны эхээр хийж гүйцэтгэсэн Монголын өөрийнх нь банкны салбарын өөрчлөлт

шинэчлэлийг бас эргэж харахад илүүдэхгүй. Дэлхийн банк нь хандивлагч бусад байгуулагуудын нэгэн адил Монгол банк болон Сангийн яамтай хамтран дээрхи төрлийн хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжүүлэлт тогтолцооны хувьд өндөр ач холбогдолтой банкуудын үнэлгээ дээр суурилж байх тал дээр анхааран ажилласан. Мөн зохистой гарах стратегиг боловсруулах, хэрэгжүүлэх тал дээр Дэлхийн банк мөн дэмжлэг үзүүлэх болно.

{ слайдуудад Монголын байдлыг харуулсан зарим хүснэгт, зураг оруулах. }

Би энэхүү үгээ өөдрөг байдлаар өндөрлөх хүсэлтэй байна. Хямралууд давтагдаад байдаг нь харамсалтай. Хамгийн сүүлийн энэ хямралаас гарах эерэг үр дүн нь дэлхийн аль ч орны эрх мэдэлтэнгүүд өөрчлөлт хийх шаардлагатайг мэдэрсэн явдал юм, энэ нь ч G-20-ийн уулзалтаас илэрхий харагдсан. Олон улсын санхүүгийн тогтолцоог зохицуулдаг, хянадаг байдлыг өөрчилсөнөөр ирэх хямралын магадлал болон ачааг мэдэгдэхүйц хөнгөлөх юм гэдэг дээр санал улам бүр нийлж байна. Эдийн засгийн өсөлтийн үед эрсдэлийг зохистой хэмжээг барих, нөгөө талаас эдийн засгийн бууралтын үед эрсдэл өсөхийн эсрэг арга хэмжээ болох “макро эдийн засгийн зохистой болгоомжлолын цар хүрээг” бүрэлдүүлэх ажил хийгдэж байна. Өнгөрсөн 9-р сард төв банкны ерөнхийлөгчдийн болон хяналт шалгалт хариуцсан захирлуудын (тэрээр Банкны хяналтын Базелийн хорооны хянан шалгах хэсэг нь) уулзалтын үеэр 2011 оны эцэс гэхэд банкуудын активын чанар, тогтвортой байдал болон ил тод байдлыг нэмэгдүүлж банкны систем дэх хэт өндөр хөшүүргийг багасгах зорилгоор дэлхий нийтээр хэрэгжүүлэх багц арга хэмжээг боловсруулж батлана гэж зарласан. Дэлхийн хэмжээнд хэрэгжүүлэх өөрчлөлт шинэчлэлийн бусад арга хэмжээний хувьд макро-болгоомжлолын шинэ зохицуулалт болон санхүүгийн даатгалын системийн загвар хоорондын уялдааг сайжруулах; тогтолцооны хувьд өндөр ач холбогдолтой банкуудыг цаг алдалгүй хаах нөхцлийг бүрдүүлэх үүднээс дампуурлын зохистой зохицуулалт буй болгох; хэрэглэгчдийг эрх ашгийг хамгаалах болон зах зээлийн авирыг зохицуулах; зах зээлийн дэд бүтцийг бэхжүүлэх зэрэг багтана. Улс төрийн бат бэх тэмүүлэл, эв нэгдэл байсан цагт Монгол Улс одоо тулгараад байгаа бэршээлүүдийг амжилттай даван туулж дэлхийн бусад ораүүдын адил мөчлөгийн горимыг хэт дагадаггүй, гадны болон дотоодын сөрөг хүчин зүйлийг эсэргүйцэх чадвартай сахүүгийн тогтолцоо хөгжүүлж чадна гэдэгт итгэлтэй байна.